



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/205

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийн үр өгөөжтэй тогтолцоо, бэлчээрийн тогтвортой менежментийн таатай орчныг бүрдүүлэхээр "Ногоон алт, Малын эрүүл мэнд" төсөлтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч:	Г.Хэрлэнчулуун	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баярхүү	-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Ж.Энх-Амгалан	-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Б.Дархантөр	-Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Л.Чулуун	-Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга
	Б.Түмэнхишиг	-Хоршоог дэмжих холбоо ТББ-ын тэргүүн
	Д.Уранчимэг	-Хэрлэн бизнес хөгжил нийгэмлэг ТББ-ын тэргүүн
		-Сумдын Засаг дарга нар

2. "Ногоон алт, Малын эрүүл мэнд" төслийн үр нөлөөг дээшлүүлэх, аймаг, орон нутгийн хэмжээнд амжилттай зохион байгуулж, ажлын явц болон үр дүнг цаг тухайд нь аймгийн Засаг даргад танилцуулж байхыг ажлын хэсэг /Г.Хэрлэнчулуун/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011002